

**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАР**



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

**МОГОЙН ГОЛ ХК-ИЙН 2025 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН
АУДИТЫН ТАЙЛАН**

Аудитын код: ХӨА-2026/020/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас:
www.audit.mn

Хөвсгөл аймаг
2026 он

Дарга, тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар
Утас:88883317 Цахим хаяг: Erdenebaatara@audit.gov.mn
Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр
Утас: 99089114 Цахим хаяг: Tegshdelgerb@audit.gov.mn
Ахлах аудитор: Б.Давааням
Утас: 88095436 Цахим хаяг: davaanyamb@audit.gov.mn
Аудитор: С.Гансүх
Утас: 95908400 Цахим хаяг: gansukhsa@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан	5
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	9
3.1 Могойн гол ХК ба түүний үйл ажиллагаа	9
3.2 Компанийн үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт	11
4. Аудитын тайлан	15
4.1 Ерөнхий зүйл	15
4.2 Материаллаг байдал	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
4.4.1 Шилэн дансны мэдээлэл	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
4.5.1 Завсрын аудитын талаар	16
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	17
4.7 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
5. Аудитын илрүүлэлт	17
5.1 Төлбөрийн акт	
3.2 Албан шаардлага	
5.3 Зөвлөмж	18
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	21

Товчилсон үгийн жагсаалт

СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ХК	Хувьцаат компани
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvs gul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2026.03.16 № 01/302
танай _____-ны № _____-т

“МОГОЙН ГОЛ” ХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Ц.БАТТОГТОХ ТАНАА

Хараат бус аудиторын дүгнэлт

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Могойн гол” ХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол “Могойн гол” ХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитаар өргөн тархаагүй боловч дараах материаллаг зөрчлүүд материаллаг байдлын түвшингээс давсан байна. Үүнд:

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн цалинг 2023 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн 174 дүгээр тогтоолоор баталсан аргачлалын дагуу тогтоогоогүйгээс Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалинг Засгийн газрын 2023 оны 84 тогтоолд заасан Төрийн өмчит компаниудын Төлөөлөн удирдах зөвлөлийн цалингийн зардлын дээд хязгаараас 23.9 сая төгрөгөөр илүү тооцож олгосон байна. Энэ нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн “Аргачлал батлах тухай” 174 дүгээр тогтоолын 3-т “Төрийн өмчийн оролцоотой компани, орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой компанийн Төлөөлөн удирдах зөвлөл, Засаг дарга, Иргэдийн төлөөлөгчдийн хуралд аргачлалыг мөрдөж ажиллахыг зөвлөсүгэй” гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.
2. Өмнөх удирдлагын буруутай үйл ажиллагаанаас тоног, төхөөрөмжийн түрээс, нүүрсийг хуурай аргаар баяжуулах үйлдвэр ашиглах гэрээ байгуулан урьдчилгаа төлбөрийн баталгаа гаргахгүйгээр урьдчилж төлбөр шилжүүлсэн, анхан шатны баримтын бүрдэлгүйгээр мөнгө зарцуулсан нийт 558.8 сая

төгрөгийн зөрчил гаргасан. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.3-т "Урьдчилгаа төлбөрийн баталгаа гаргаагүй бол захиалагч урьдчилгаа төлбөр төлөхийг хориглоно", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3. Төлөөлөн удирдах зөвлөлөөс баталсан нүүрсний борлуулалтын орлогын төлөвлөгөөг 361.8 мянган тонноор дутуу буюу 67.0 хувиар дутуу биелүүлж, зорилтот түвшнээс 2,277.6 сая төгрөгөөр дутуу буюу 1,090.9 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1.3-т "Захирал дараах эрх, үүрэгтэй: үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах;" , Могойн гол ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс 2024 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 8 дугаар тогтоолоор баталсан бизнес төлөвлөгөөнд нийцэхгүй, санхүүгийн тайлангийн "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.
4. Урьдчилж орсон орлогоор бүртгэгдсэн 8 компанийн 8,239.1 сая төгрөг, дансны өглөгөөр бүртгэгдсэн 11 компанийн 2,249.1 сая төгрөг нийт 10,488.3 сая төгрөгийн өр төлбөр, 67.6 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.1-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ: жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө;" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн "Эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт орж, гүйцэтгэх захирлыг шинээр томилсон байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Аудитаар нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой 583.2 сая төгрөгийн 1 алдааг залруулж, тасралтгүй үйл ажиллагаа явуулах чадвар, бизнес төлөвлөгөөний биелэлт, зардлын данс, худалдан авах ажиллагаа, өмнөх аудитын шийдвэрийн хэрэгжилт, дотоод хяналттай холбоотой нийт 13,378.0 сая төгрөгийн 9 зөрчил илрүүлж, илэрсэн зөрчлийг арилгах 2 албан шаардлага, 7 зөвлөмж өгсөн.

Бусад асуудал

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

"Могойн гол"ХК тайлант онд 847.4 мянган м.куб хөрс хуулалтын ажил гүйцэтгэж, 198.2 мянган тонн нүүрс олборлож, 178.2 тонн нүүрс борлуулсан байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Төгрөг

Мөрийн дугаар	Балансын зүйл	Үлдэгдэл	
		1 сарын 1	12 сарын 31
1.1.01	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	20,541,295.51	101,115,918.12
1.1.02	Дансны авлага	526,774,114.55	1,456,529,147.27
1.1.03	Татвар, НДШ-ийн авлага	20,028,838.20	20,028,838.20
1.1.04	Бусад авлага	38,003,762.97	34,900,143.13
1.1.06	Бараа материал	16,573,378,784.98	13,181,925,102.70
1.1.07	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	668,727,329.61	694,791,263.61
1.1.08	Бусад эргэлтийн хөрөнгө	446,592.59	0.00
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	17,847,900,718.41	15,489,290,413.03
1.2.01	Үндсэн хөрөнгө	3,167,651,623.53	3,283,009,684.09
1.2.02	Биет бус хөрөнгө	193,366,764.66	153,628,237.46
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	3,361,018,388.19	3,436,637,921.55
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	21,208,919,106.60	18,925,928,334.58
2.1.1.01	Дансны өглөг	8,971,335,061.23	8,840,240,223.23
2.1.1.02	Цалингийн өглөг	148,987,747.71	0.00
2.1.1.03	Татварын өр	599,393,850.84	1,983,206,571.61
2.1.1.04	НДШ - ийн өглөг	267,862,972.61	749,319,202.93
2.1.1.05	Богино хугацаат зээл	1,212,000,000.00	1,047,959,631.76
2.1.1.07	Ногдол ашгийн өглөг	477,773,200.00	434,874,200.00
2.1.1.08	Урьдчилж орсон орлого	5,337,656,392.21	2,523,150,200.25
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	8,469,415.00	252,595,289.00
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	17,023,478,639.60	15,831,345,318.78
2.1.2.04	Бусад урт хугацаат өр төлбөр	789,830,990.80	789,830,990.80
2.1.2.06	Урт хугацаат өр төлбөрийн дүн	789,830,990.80	789,830,990.80
2.2	Өр төлбөрийн нийт дүн	17,813,309,630.40	16,621,176,309.58
2.3.01	Өмч: - төрийн	42,310,722.00	42,310,722.00
2.3.02	- хувийн	40,651,478.00	40,651,478.00
2.3.06	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	1,375,789,181.23	1,375,789,181.23
2.3.08	Эздийн өмчийн бусад хэсэг	202,833,326.81	202,833,326.81
2.3.09	Хуримтлагдсан ашиг	1,734,024,768.16	643,167,316.96
2.3.09.1	Тайлангийн үеийн ашиг	0.00	(1,090,857,451.20)
2.3.09.2	Өмнөх үеийн ашиг	1,734,024,768.16	1,734,024,768.16
2.3.11	Эздийн өмчийн дүн	3,395,609,476.20	2,304,752,025.00
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	21,208,919,106.60	18,925,928,334.58

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

Төгрөг

Мөрийн дугаар	Балансын зүйл	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
01	Борлуулалтын орлого (цэвэр)	6,735,121,637.90	11,096,079,322.99
02	Борлуулалтын өртөг	6,013,803,916.54	10,145,037,320.08
03	Нийт ашиг(алдагдал)	721,317,721.36	951,042,002.91

08	Бусад орлого	48,824,326.78	42,140,704.55
09	Борлуулалт, маркетингийн зардал	48,824,326.78	42,140,704.55
10	Ерөнхий ба удирдлагын зардал	476,847,216.59	512,531,942.19
12	Бусад зардал	1,154,038,606.53	1,085,237,416.32
12.1	Зардлын дүн	130,881,101.47	442,635,800.15
18	Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)	1,761,766,924.59	2,040,405,158.66
20	Татварын дараах ашиг (алдагдал)	-991,624,876.45	(1,090,857,451.20)
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-991,624,876.45	(1,090,857,451.20)

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Төгрөг

№	Үзүүлэлт	Өмч	Хөр-н дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
01	2023 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	82,962,200.00	1,375,789,181.23	202,833,326.81	3,223,422,844.61	4,885,007,552.65
02	НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.00	0.00	0.00	-497,773,200.00	-497,773,200.00
03	Залруулсан үлдэгдэл	82,962,200.00	1,375,789,181.23	202,833,326.81	2,725,649,644.61	4,387,234,352.65
04	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	-991,624,876.45	-991,624,876.45
09	2024 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	82,962,200.00	1,375,789,181.23	202,833,326.81	1,734,024,768.16	3,395,609,476.20
02	НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.00	0.00	0.00	0.00	0.00
03	Залруулсан үлдэгдэл	82,962,200.00	1,375,789,181.23	202,833,326.81	1,734,024,768.16	3,395,609,476.20
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	(1,090,857,451.20)	-1,630,450,362.24
17	2025 оны 12 сарын 31-р үлдэгдэл	82,962,200.00	1,375,789,181.23	202,833,326.81	643,167,316.96	2,304,752,025.00

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Төгрөг

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	9,225,481,040.00	6,340,083,672.42
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	9,137,221,879.00	6,265,859,487.40
1.1.6	Бусад мөнгөн орлого	88,259,161.00	74,224,185.02
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	8,968,813,308.54	6,072,968,781.57
1.2.1	Ажиллагчдад төлсөн	2,365,380,420.00	2,144,732,599.71
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	512,976,414.03	205,000,000.00
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	563,190,886.15	916,106,385.70
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	140,572,964.41	89,214,547.99
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	2,605,771,007.75	1,407,786,945.00
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	90,093,106.86	240,251,544.55
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	694,143,041.27	111,629,170.00

1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	8,938,000.00	55,148,891.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	1,987,747,468.07	903,098,697.62
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	256,667,731.46	267,114,890.85
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	1,528,601,600.00	2,499,900.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	1,488,801,600.00	2,499,900.00
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	39,800,000.00	0.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-1,528,601,600.00	-2,499,900.00
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	1,212,000,000.00	0.00
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	1,212,000,000.00	0.00
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	20,000,000.00	184,040,368.24
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	0.00	164,040,368.24
3.2.4	Төлсөн ногдол ашиг	20,000,000.00	20,000,000.00
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	1,192,000,000.00	-184,040,368.24
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	-79,933,868.54	80,574,622.61
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	146,272,287.03	20,541,295.51
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	20,541,295.51	101,115,918.12

2.5 Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин

мянган төгрөг

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2025 оны		Биелэлт	
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Мөнгөн дүн	Хувь
1	Урд оноос шилжсэн нүүрс	мян.тн	62.3	62.7	-0.4	100.6
2	Хөрс хуулалт/мян.м3/	мян.м3	4,200.00	847.4	3,352.60	20.2
3	Олборлох нүүрсний хэмжээ	мян.тн	500	198.2	301.8	39.6
4	Борлуулах нүүрсний хэмжээ	мян.тн	540	178.2	361.8	33
5	Нийт орлого	мян.төг	55,530,000.00	11,138,219.60	44,391,780.40	20.1
6	Үндсэн үйл ажиллагааны борлуулалтын орлого	мян.төг	55,200,000.00	10,771,686.90	-44,428,313.10	19.5
7	Туслах үйл ажиллагааны борлуулалтын орлого	мян.төг	170,000.00	303,809.20	133,809.20	178.7
8	Үйл ажиллагааны бус орлого	мян.төг	115,000.00	20,582.80	-94,417.20	17.9
9	Халаалтын орлого	мян.төг	45,000.00	42,140.70	-2,859.30	93.6
10	Нийт зардал	мян.төг	54,343,247.00	12,229,077.00	-42,114,170.00	22.5
11	Нүүрсний борлуулалтын өртөг	мян.төг	50,128,400.30	9,729,649.00	-40,398,751.30	19.4
12	Нүүрснээс бусад бараа	мян.төг	150,000.00	281,239.20	131,239.20	187.5

	материал борлуулсны өртөг					
13	Уурын зуухны зардал	мян.төг	233,475.20	163,887.40	-69,587.80	70.2
14	Туслах үйл ажиллагааны зардал	мян.төг	69,887.30	9,671.10	-60,216.20	13.8
15	Удирдлагын зардал	мян.төг	1,451,811.90	1,110,573.00	-341,238.90	76.5
16	Борлуулалтын ажиллагааны зардал	мян.төг	2,101,056.30	512,531.90	-1,588,524.40	24.4
17	Үйл ажиллагааны бус зардал	мян.төг	208,616.00	421,525.40	212,909.40	202.1
18	Татварын өмнөх ашиг /алдагдал/	мян.төг	1,186,753.00	-1,090,857.40	-2,277,610.40	-91.9
19	Орлогын албан татвар	мян.төг	118,675.30		-118,675.30	0.0
20	Цэвэр ашиг /алдагдал/	мян.төг	1,068,077.70	(1,090,857.4)	2,158,935.10	

Санхүүгийн тайлангийн тодруулга

3.1 Могойн гол ХК ба түүний үйл ажиллагаа

Могойн гол ХК нь 1970 онд Могойн голын уурхай нэрээр анх үүсгэн байгуулагдаж байсан бөгөөд Монгол улсын Засгийн газрын Өмч хувьчлалын комиссын 1994 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн 35 дугаар тогтоолоор хувьцаат компани болгон өөрчлөн байгуулсан байна. Могойн гол ХК нь 51 хувийн орон нутгийн өмчийн оролцоотой компани бөгөөд 49 хувийг бусад хувьцаа эзэмшигчид эзэмшиж байна. Нийт хувьцааны тоо 829,622 ширхэг ба үүнээс Хөвсгөл аймгийн ИТХ 423,107 ширхэг, цөөнх хувьцаа эзэмшигчид 406,515 ширхэг хувьцаа эзэмшиж байна.

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нэгж хувьцааны зах зээлийн үнэ /14,500 төгрөг/ нэгж хувьцааны дансны үнээс /2,075 төгрөг/ өндөр байгаа нь компанийн хөрөнгийн бодит үнэ дансны үнээс өндөр байгааг харуулж байна.

Могойн гол ХК-ийн ТУЗ нь 9 гишүүн, үүнээс орон нутгийн өмчийн төлөөлөл 5 гишүүн, цөөнх хувьцаа эзэмшигчдийн төлөөлөл 4 гишүүнээс бүрдэж байна. Компанийн зорилго нь үйл ажиллагаандаа орчин үеийн дэвшилтэт технологийг нэвтрүүлэн олон улсын чанар стандартад нийцүүлсэн нүүрсийг олборлож, ажилтнуудаа аюулгүй орчинд сэтгэл хангалуун ажиллаж өсөх дэвших боломжоор ханган ажиллаж эдийн засгийн хувьд бие даасан орон нутгийн хөгжлийг тэргүүлэгч компани болоход оршино. Могойн гол ХК-ийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Монгол улсанд ашигт малтмалын хайгуул, олборлолт хийх болон хэрэв боломжтой гэж үзвэл боловсруулах
- Ашигт малтмалыг боловсруулах, тоног төхөөрөмж, өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүн худалдах худалдан авах импортлох, экспортлох зэргээр гадаад дотоод худалдаа эрхлэх
- Монгол улсын хууль тогтоомжоор хориглоогүй бусад төрлийн үйл ажиллагаа эрхлэх

Могойн гол ХК нь эрчим хүчний болон коксжих нүүрс олборлож, ААН, иргэдэд борлуулах үндсэн үйл ажиллагааг эрхэлдэг ба тайлант хугацаанд үндсэн үйл ажиллагаанаас гадна уурын зуухаар дулаан үйлдвэрлэж өөрийн хэрэгцээнд болон багийн төвд үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудыг дулаанаар хангах үйл ажиллагаа эрхэлдэг байна.

3.2 Компанийн гадаад, дотоод орчин

Могойн гол ХК нь эрчим хүчний болон коксжих нүүрсний борлуулалт хийдэг ба эрчим хүчний нүүрсний борлуулалтаас алдагдал хүлээж, коксжих нүүрсний борлуулалтаас алдагдлаа нөхөж байдаг. Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль 2022 оны 12 сарын 23-нд УИХ-аар батлагдаж, 2023 оны 6 сарын 30-ны өдрөөс дагаж мөрдөхөөр хуульчлагдсан. Энэ хуулийн "10.2.Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн борлуулах энэ хуулийн 10.1-д заасан уул уурхайн бүтээгдэхүүнийг биржээр заавал арилжина." заалтын дагуу коксжих нүүрсээ биржээр зарж борлуулах шаардлагатай. Бирж дээр нүүрс борлуулахын тулд Эрдэнэт хотод итгэмжлэгдсэн гаалийн талбайтай байх ёстой. Компанийн хувьд хуулийн дагуу биржээр нүүрс борлуулахад хүндрэлтэй байгаа тул удирдлагаас АҮЭБЯ-ны биржийн хуулийн ажлын хэсэгт хүсэлт гаргасан боловч одоог хүртэл шийдвэрлэгдээгүй байна. Иймд 2025 онд нүүрсийг дотоодын зах зээлд худалдан борлуулсан байна.

Тайлант онд 4,200.0 мянган тонн хөрс хуулалтын ажил хийж 500.0 мянган тонн нүүрс олборлож, 540.0 мянган тонн нүүрс борлуулах зорилго тавьж ажилласнаас 847.4 мянган тонн хөрс хуулалтын ажил хийж 198.2 мянган тонн нүүрс олборлож, 178.2 мянган тонн нүүрс борлуулжээ. Дээрх байдлаас харахад компани хөрс хуулалт бизнес төлөвлөгөөнд заасан хэмжээний 20.2 хувьд хүрсэн үзүүлэлттэй байна. Дээрх гадаад дотоод таагүй хүчин зүйлс нь компанийн тасралтгүй үйл ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлж байна.

Компанийн үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

Тус компанид дараах хууль эрх зүйн зохицуулалтуудыг үйл ажиллагаандаа голлон ашиглаж байна. Үүнд:

- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль,
- Компанийн тухай хууль,
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль,
- Ашигт малтмалын тухай хууль,
- Уул уурхайн биржийн тухай хууль,
- Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль,
- Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хууль,
- Хөвсгөл аймгийн ИТХ-ын тогтоол,
- Могойн гол ХК-ийн ТУЗ-ын тогтоол
- Бусад холбогдох хууль.

Тайлант хугацаанд дээрх хуулиудад тус аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд нөлөөлөхүйц хэмжээний өөрчлөлт гаргаагүй байна.

Байгууллагын дотоод хяналтын талаар:

Компанийн дотоод хяналт ТУЗ болон гүйцэтгэх удирдлагын түвшинд хэрэгждэг. Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам¹-ийн дагуу компанийн захирлын 2022 оны 05 сарын 12-ны өдрийн А-28 тоот тушаалаар дотоод хяналт шалгалтын нэгжийг байгуулсан байна.

Дотоод хяналтын ажлын хэсэг нь 2025 онд хэрэгжүүлэх бизнес төлөвлөгөөнд тусгагдаж батлуулсан зардлууд болон норм нормативыг мөрдөж байгаа эсэх, түлш шатахуун, цалин, хоолны зардлыг зориулалтын дагуу зарцуулж байгаа эсэхэд хяналт тавихаар төлөвлөсөн боловч хэрэгжүүлээгүй байна. Энэ нь Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын хавсралт "Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ын 3.1¹ дэх заалт болон "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Зөвлөмж өгөх

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Могойн гол ХК-ийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэх үүрэгтэй. Аккрузал сууриар бүртгээгүйтэй холбоотой алдааг 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлтөд тусгасан.

Могойн гол ХК нь 2022 оны 11 дүгээр сараас нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн мөрдөж байгаа ба нягтлан бодох бүртгэлд UNICUS программыг ашигладаг.

¹ Энэхүү журмын 1.3-т заасан "Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам"-д өөрөөр заагаагүй бол дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах үүргийг тухайн аж ахуйн нэгж, байгууллагын захиргааны асуудал хариуцсан нэгж, ажилтан (цаашид "дотоод хяналт шалгалтын нэгж, ажилтан" гэх) гүйцэтгэнэ.

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

Могойн гол ХК санхүүгийн тайлангаа Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Компани нь Могойн гол ХК-ийн санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэдэг ба бараа материалыг эхэлж зарлагадах аргаар бүртгэж тайлагнадаг.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2,283.0 сая төгрөгөөр буюу 13.5 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

				/мянган төг/
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт	
Б	1	2	3=2-1	
Мөнгөн хөрөнгө	20,541.3	101,115.9	80,574.6	
Авлага	584,806.7	1,511,458.1	926,651.4	
Бараа материал	16,573,378.8	13,181,925.1	-3,391,453.7	
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	668,727.3	694,791.3	26,063.9	
Бусад эргэлтийн хөрөнгө	11.7	0.4	-11.3	
Үндсэн хөрөнгө	3,167,651.6	3,283,009.7	115,358.1	
Биет бус хөрөнгө	193,366.8	153,628.2	-39,738.5	
Нийт хөрөнгө	21,208,919.1	18,925,928.3	-2,282,990.8	
Богино хугацаат төлбөр	17,023,478.6	15,831,345.3	-1,192,133.3	
Урт хугацаат өр төлбөрийн дүн	789,831.0	789,831.0	0.0	
Эздийн өмч	3,395,609.5	2,304,752.0	-1,090,857.5	
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	21,208,919.1	18,925,928.3	-2,282,990.8	

Хөрөнгө, өр төлбөрт орсон өөрчлөлтийг тодруулбал дараах байдалтай байна. Үүнд:

1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 101.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй өмнөх оноос 80.6 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.
2. Авлагын дансны үлдэгдэл өмнөх оноос 926.6 сая төгрөгөөр өсөхөд дансны авлага өссөн нь нөлөөлжээ. Найдваргүй авлагын нөөцийг шууд аргаар байгуулдаг ба 125.5 сая төгрөг ба тайлант онд өөрчлөлт ороогүй байна.
3. Бараа материал данс 3,391.4 сая төгрөгөөр буурахад олборлосон нүүрсний үлдэгдэл 2,558.9 сая төгрөгөөр буурсан нь гол нөлөө үзүүлжээ.
4. Үндсэн хөрөнгө 115.3 сая төгрөгөөр өсөхөд тайлант үед 583.2 сая төгрөгийг капиталжуулж, тоног төхөөрөмж ка элэгдлийн зардал 510.4 сая төгрөг байсан нь гол нөлөө үзүүлсэн байна.
5. Богино хугацаат өр төлбөр 1,192.1 сая төгрөгөөр буурахад урьдчилж орсон орлого 2,814.5 сая төгрөгөөр буурсан нь гол нөлөө үзүүлсэн ба татварын өглөг 1,383.8 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.
6. Эзний өмч 1,674.1 сая төгрөгөөр буурсан нь тайлант үеийн алдагдлаас хамаарсан байна.

Дээрх данснуудтай холбоотой дараах зөрчлүүд илэрсэн. Үүнд:

Илрүүлэлт 1:

Эксковатор 5а машинд 583,227,911.04 төгрөгийн их засварыг капиталжуулаагүй байна. Энэ нь НББОУС-16 "Үндсэн хөрөнгийн ашиглалтын явцад гарсан зардал нь хөрөнгийн

ашиглалтын хугацаа эсвэл хүчин чадлыг нэмэгдүүлж байвал хөрөнгийн анхны өртөгт капиталжуулна” заалт болон санхүүгийн тайлангийн “үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Залруулга хийх

Илрүүлэлт 2:

“Могойн гол” ХК-ийн 2025 оны завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар талбар дээр биет тооллогыг 54-н машин тоног төхөөрөмж, тээврийн хэрэгслийг хамруулан түүвэрлэн үзэхэд 171.0 сая төгрөгийн анхны өртөгтэй элэгдлээрээ өртгөө нөхсөн цаашид ашиглах боломжгүй 20 хөрөнгийг өмч хамгаалах байнгын зөвлөлөөр хэлэлцэж шийдвэрлээгүй байна. Энэ нь: НББОУС 16-д үндсэн хөрөнгийн тодорхойлолтод нийцсэн, дараах хоёр шалгуурыг хангасан хөрөнгийг үндсэн хөрөнгөөр хүлээн зөвшөөрнө: Тухайн хөрөнгөтэй холбоотой ирээдүйн эдийн засгийн үр өгөөж нь тухайн аж ахуйн нэгжид орох магадлалтай байх... гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөвлөмж өгөх

Илрүүлэлт 3:

Цэрмүүнтрейд ХХК-иас худалдан авсан ЭКГ-5А эксковаторын сэлбэгийн тооцооноос үүссэн 67.6 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна. Энэ нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-т “Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөвлөмж өгөх

Урьдчилж орсон орлогоор бүртгэгдсэн 8 компанийн 8,239.1 сая төгрөг, дансны өглөгөөр бүртгэгдсэн 11 компанийн 2,249.1 төгрөг нийт 10, 488.3 сая төгрөгийн өр төлбөрийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна. Энэ нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-т “Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөвлөмж өгөх

Илрүүлэлт 4:

2025 оны онд Могойн гол ХК-ийн богино хугацаат өглөг 1,192.1 сая төгрөгөөр буурсан боловч нийт дүнгээр 15,831.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь компанийн хэвийн үйл ажиллагаа явуулахад хангалтгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөвлөмж өгөх

Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөө

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 1.3-д заасны дагуу Компанийн гүйцэтгэх захирал нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Тус компанийн 2025 оны бизнес төлөвлөгөөг төлөөлөн удирдах зөвлөлөөс баталсан байна. “Могойн гол” ХК-ийн ТУЗ нь 2025 оны 01 дүгээр сарын 24-ний 01 дүгээр тогтоолоор компанийн 55,530.0 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 54,343.2 сая төгрөгийн зардал гарган, 1,186.7 сая төгрөгийн ашигтай ажиллахаар тогтоосон байна.

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний биелэлт

Гүйцэтгэлээр 11,138.2 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 12,229.1 сая төгрөгийн зардал гарган, 1,090.9 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

График 1. Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэлийг биет хэмжээгээр харуулбал:

Зорилтот түвшин



Нийт орлогын гүйцэтгэл 11,138.2 сая төгрөг болж 1,090.9 сая төгрөгийн алдагдалтай ажилласан нь коксжих нүүрсний орлого буурснаас шалтгаалжээ.

Нийт зардлын гүйцэтгэл 12,229.1 сая төгрөг болж, төлөвлөгөөнөөс 77,5 хувиар дутуу гүйцэтгэлтэй байна. Энэ нь тайлант онд төлөвлөсөн нүүрс борлуулалтаа 67.0 хувиар дутуу гүйцэтгэсэнтэй холбоотой байна.

Тайлант онд алдагдалтай ажилласан тул ногдол ашиг зарлаагүй байна.

Компанийн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний биелэлтийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 3. 2025 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/мянган төгрөг/

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2025 оны		Биелэлт	
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Мөнгөн дүн	Хувь
1	Урд оноос шилжсэн нүүрс	мян.тн	62.3	62.7	-0.4	100.6
2	Хөрс хуулалт/мян.м3/	мян.м3	4,200.00	847.4	3,352.60	20.2
3	Олборлох нүүрсний хэмжээ	мян.тн	500	198.2	301.8	39.6
4	Борлуулах нүүрсний хэмжээ	мян.тн	540	178.2	361.8	33
5	Нийт орлого	мян.төг	55,530,000.00	11,138,219.60	44,391,780.40	20.1
6	Үндсэн үйл ажиллагааны борлуулалтын орлого	мян.төг	55,200,000.00	10,771,686.90	-44,428,313.10	19.5
7	Туслах үйл ажиллагааны борлуулалтын орлого	мян.төг	170,000.00	303,809.20	133,809.20	178.7
8	Үйл ажиллагааны бус орлого	мян.төг	115,000.00	20,582.80	-94,417.20	17.9
9	Халаалтын орлого	мян.төг	45,000.00	42,140.70	-2,859.30	93.6
10	Нийт зардал	мян.төг	54,343,247.00	12,229,077.00	-42,114,170.00	22.5
11	Нүүрсний борлуулалтын өртөг	мян.төг	50,128,400.30	9,729,649.00	-40,398,751.30	19.4
12	Нүүрснээс бусад бараа материал борлуулсны өртөг	мян.төг	150,000.00	281,239.20	131,239.20	187.5
13	Уурын зуухны зардал	мян.төг	233,475.20	163,887.40	-69,587.80	70.2

14	Туслах үйл ажиллагааны зардал	мян.төг	69,887.30	9,671.10	-60,216.20	13.8
15	Удирдлагын зардал	мян.төг	1,451,811.90	1,110,573.00	-341,238.90	76.5
16	Борлуулалтын ажиллагааны зардал	мян.төг	2,101,056.30	512,531.90	-1,588,524.40	24.4
17	Үйл ажиллагааны бус зардал	мян.төг	208,616.00	421,525.40	212,909.40	202.1
18	Татварын өмнөх ашиг /алдагдал/	мян.төг	1,186,753.00	-1,090,857.40	-2,277,610.40	-91.9
19	Орлогын албан татвар	мян.төг	118,675.30		-118,675.30	0.0
20	Цэвэр ашиг /алдагдал/	мян.төг	1,068,077.70	(1,090,857.4)	2,158,935.10	

Зорилтот түвшний гүйцэтгэлтэй холбоотой дараах алдаа зөрчил илэрлээ. Үүнд:

Илрүүлэлт:

ТУЗ-өөс баталсан нүүрсний борлуулалтын орлогын төлөвлөгөөг 361.8 мянган тонноор дутуу буюу 67.0 %-аар дутуу биелүүлж, зорилтот түвшнээс 2,277.6 сая төгрөгөөр дутуу буюу 1,090.8 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20.1 "Захирал дараах эрх, үүрэгтэй: ...3/үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах..." заалт, Могойн гол ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс 2024 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 8 дугаар тогтоолоор баталсан бизнес төлөвлөгөөг биелүүлээгүй ба "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Зөвлөмж өгөх.

Илрүүлэлт:

"Могойн гол" ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2025 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн хурлын шийдвэрээр Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний цалинг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн "Аргачлал батлах тухай" 174 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан аргачлалд нийцүүлэн тооцохгүйгээр 3.5 сая төгрөгөөр тогтоосноос Засгийн газрын 2023 оны 84 тогтоолд заасан Төрийн өмчит компаниудын ТУЗ-ын цалингийн зардлын дээд хязгаараас 23.9 сая төгрөгөөр илүү тооцсон байна. Энэ нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн "Аргачлал батлах тухай" 174 дүгээр тогтоолын 3 дахь заалт "Төрийн өмчийн оролцоотой компани, орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой компанийн Төлөөлөн удирдах зөвлөл, Засаг дарга, Иргэдийн төлөөлөгчдийн хуралд аргачлалыг мөрдөж ажиллахыг зөвлөсүгэй"-тай нийцээгүй, санхүүгийн тайлангийн "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэлт:

Төлөөлөн удирдах зөвлөлд албан шаардлага өгөх

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт, орлого, зардлын зүйлс тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5 Ерөнхий чиглэлийн хүрээнд авсан судалгааны үр дүнгийн талаар:

- Могойн гол ХК нь тайлант онд ажилчдын цайны газар ажиллуулдаг ба ажилчдын хоолны зардалд 70 хувийн хөнгөлөлт үзүүлдэг.
- Гадаад томилолт, арга хэмжээ зохион байгуулаагүй

- Санхүү бүртгэлийн чиглэлээр санхүү, борлуулалт, шаардах хуудас хөтлөх 3 программ хангаж ашигладаг ба 76.9 сая төгрөгийн анхны өртөгтэй, 19.4 сая төгрөгийн дансны үнэтэй ашиглаагүй программ байхгүй.
- Хурал, цуглаантай холбоотой ажил гүйлгээ гараагүй
- Дээд шатны удирдах албан тушаалтай 2 хүний цалинд 108.7 сая төгрөгийг олгосон ба нийт 11,138.2 сая төгрөгийн орлоготой, 12,812.3 сая төгрөгийн зардалтай ажилласан байна. Төлөвлөсөн ашиг 1,186.7 сая төгрөг боловч гүйцэтгэлээр 1,674.1 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.
- Төлөвлөсөн орон тоо 187, цалингийн зардал 3,391.1 сая төгрөг байсан ба гүйцэтгэлээр 106 орон тоотой, 2,704.1 сая төгрөгийн цалингийн зардалтай ажилласан байна. Төлөвлөсөн орон тоог 43.3 хувиар бууруулсан байна.

4. Аудитын тайлан

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Могойн гол ХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл, үндсэн хөрөнгө, дотоод хяналт, авлага, төлбөр, ТУЗ-тэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор С.Гансүх гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Г.Ичинхорлоо, аудитын менежер Б.Тэгшдэлгэр, дарга, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Могойн гол ХК-ийн 2025 оны санхүүгийн тайланг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 01/18 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлын 7,775.6 сая төгрөгөөс 2 хувиар буюу 155.5 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 124.4 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд орон нутгийн өмчит хуулийн этгээдийн авч хэрэгжүүлсэн байдлыг Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийн аудитаар шалгана.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

- Тендерт шалгарсан болон шалгараагүй талаарх товч мэдээлэл
- Цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ
- Төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн мэдээлэл
- Худалдан авах ажиллагаатай холбоотой мэдээлэл

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Компанийн удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бусад мэдээлэл болох бизнес төлөвлөгөөний тайлан, үйлдвэрлэлийн бусад үйл ажиллагаа, худалдан авах ажиллагааны тайлан зэрэг нь санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, гүйцэтгэлийн талаар

Тайлант онд нийт 40 бараа, ажил, үйлчилгээг 3,475.6 сая төгрөгөөр худалдан авахаар төлөвлөж, гүйцэтгэлээр 32 бараа, ажил, үйлчилгээнд 1,843.7 сая төгрөгийг зарцуулсан байна.

Худалдан авах ажиллагаа 59.5 хувийн гүйцэтгэлтэй байгаа нь төлөвлөсөн орлого тасарсантай холбоотой байна. Худалдан авах ажиллагаатай холбоотой зөрчлийг 3.5-д тусгасан.

Илрүүлэлт:

“Могойн гол” ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 2 дугаар тогтоолоор баталсан худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан 9 арга хэмжээг хэрэгжүүлэхдээ Худалдан авахад баримтлах төсөвт өртөгийн дээд хязгаарыг баримтлаагүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 “Энэ хуулийн 31.2-т зааснаас бусад тохиолдолд нийт төсөвт өртөг нь шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил, үйлчилгээг захиалагч шууд худалдан авч болно.” Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 02 дугаар тогтоолтой нийцэхгүй байна.

Шийдвэрлэлт:

Зөвлөмж өгөх.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар 3,596.5 сая төгрөгийн 7 зөрчил илрүүлж, нягтлан бодох бүртгэл, ТУЗ-ын зардал, авлагатай холбоотой 555.8 сая төгрөгийн 5 зөрчилд зөвлөмж өгч, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, худалдан авах ажиллагаатай 558.8 сая төгрөгийн 2 зөрчилд албан шаардлага өгсөн. Тайлант хугацаанд 4 зөвлөмжийг дутуу хэрэгжүүлж, 558.8 сая

төгрөгийн албан шаардлагын хугацаа болоогүй тул аудитын зөрчлийн дүнд нэгтгэн орууллаа.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар 5 зөвлөмж өгснөөс 4 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж, 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон 21.9 сая төгрөгийн 1 төлбөрийн акт одоог хүртэл төлөгдөөгүй байна.

Хүснэгт 2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитаар өгсөн		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт /2022 оны СТА/	1	21,966.5	0	0.0	0.0
Зөвлөмж	5	3,606,069.0	4	2,916,470.6	60.0
Нийт дүн	12	3,150,339.8	9	2,969,399.7	75.0

Илрүүлэлт: Өмнөх аудитаар тоног төхөөрөмжийн түрээсийн гэрээ болон хуурай аргаар баяжуулах үйлдвэрийн худалдан авах гэрээний хэрэгжилтийг хангах зөвлөмж өгснийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэлт: Завсрын аудитаар албан шаардлага өгсөн.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Аудитаар дараах компанийн тасралтгүй үйл ажиллагаа явуулах чадварын асуудлыг дараагийн аудитаар анхаарах асуудал гэж үзлээ.

5. Аудитын илрүүлэлт

5.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой 583.2 сая төгрөгийн 1 алдааг залрууллаа.

Эксковатор 5а машинд их засвар хийхэд зарцуулсан 583.2 сая төгрөгийг капиталжуулаагүй байсныг залрууллаа.

Аудитаар нийт 2,822.1 сая төгрөгийн 9 зөрчил илрүүлж, илэрсэн зөрчлийг арилгах 2 албан шаардлага, 7 зөвлөмж өглөө.

5.2 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй болно.

5.3 Албан шаардлага

Албан шаардлага-1

1.Могойн гол ХК нь 2022 оны 07 дугаар сарын 02-ны өдөр Таван хаан коул ХХК-тай Нүүрсийг хуурай аргаар баяжуулах үйлдвэрийг лизингийн хэлбэрээр ашиглах тухай гэрээг байгуулан, нийт өртөгт 665.0 сая төгрөгийг төлөхөөр 2 жилийн хугацаатай гэрээг байгуулж, гүйцэтгэлийн баталгаагүйгээр 221.0 сая төгрөгийн санхүүжилтийг урьдчилж олгосон зөрчилд 2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар зөрчлийг арилгах албан шаардлага, 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар гэрээний хэрэгжилтийг хангуулж ажиллах зөвлөмж өгснийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

2. Хөрс хуулалтын ажилд хэрэглэхээр Түасиа ХХК –аас 1 ш бульдозер, 4 ширхэг өөрөө буулгагч Хова автомашин, 1 өрмийн машиныг 2023 онд түрээсийн гэрээгээр түрээсэлсэн боловч техникүүд нь шаардлага хангахгүй эвдэрч ашиглагдаагүй байна. Гэтэл түрээслэгч компанид гүйцэтгэлийн баталгаагүйгээр 311.7 сая төгрөгийн санхүүжилтийг урьдчилж олгосон зөрчилд 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар авлага барагдуулах зөвлөмж, 2024 оны санхүүгийн тайлангийн гэрээний хэрэгжилтийг хангуулж ажиллах зөвлөмж өгснийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

3. Тайлант онд худалдан авах гэрээгүй "Зүүн нуур" ХХК-д шатахууны үнэ 16.8 сая төгрөг, гүйцэтгэх захирал асан Б.Батхүүгийн хувийн дансанд 9.2 сая төгрөг нийт 26.3 сая төгрөгийг шилжүүлж, тухайн байгууллага болон Төлөөлөн удирдах зөвлөлийн баталсан удирдамж, төлөвлөгөө, томилолтын хуудас, тайлан, илтгэх хуудас, жолоочийн тооцооны хуудасгүйгээр зарцуулсан байна. Анхан шатны баримтын бүрдэлгүй зарцуулсан зөрчилд 2023 оны санхүүгийн тайлангаар аудитын явцад гүйцэтгэх захирлаар хохирлыг барагдуулж, зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж, 2024 оны санхүүгийн тайлангаар компанийн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт хэрэгжүүлэх зөвлөмж өгснийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Дээрх зөрчлүүд нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.3-т "Урьдчилгаа төлбөрийн баталгаа гаргаагүй бол захиалагч урьдчилгаа төлбөр төлөхийг хориглоно", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", гэж заасныг тус тус зөрчсөн тул Хөвсгөл аймгийн ИТХ-д хууль, хяналтын байгууллагад шилжүүлж шийдвэрлүүлэх албан шаардлага өгсөн.

Албан шаардлага-2

"Могойн гол" ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2025 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн хурлын шийдвэрээр Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний цалинг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн "Аргачлал батлах тухай" 174 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан аргачлалд нийцүүлэн тооцохгүйгээр 3.5 сая төгрөгөөр тогтоосноос Засгийн газрын 2023 оны 84 тогтоолд заасан Төрийн өмчит компаниудын ТУЗ-ын цалингийн зардлын дээд хязгаараас 23.9 төгрөгөөр илүү тооцож, олгосон байна. Энэ нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн "Аргачлал батлах тухай" 174 дүгээр тогтоолын 3 дахь заалт "Төрийн өмчийн оролцоотой компани, орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой компанийн Төлөөлөн удирдах зөвлөл, Засаг дарга, Иргэдийн төлөөлөгчдийн хуралд аргачлалыг мөрдөж ажиллахыг зөвлөсүгэй"-тай нийцээгүй, санхүүгийн тайлангийн "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна. Иймд ТУЗ-д Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний цалинг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн 174 дүгээр тогтоолоор баталсан аргачлалын дагуу тогтоож, Хувьцаа эзэмшигчдийн хурлаар батлуулахд албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Төлөөлөн удирдах зөвлөлд:

1. Компанийн санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тайлант онд Могойн гол ХК-ийн богино хугацаат өглөг 1,192.1 сая төгрөгөөр буурсан боловч нийт дүнгээр 15,831.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь компанийн хэвийн үйл ажиллагаа явуулахад хангалтгүй, шүүхийн шийдвэрээр компанийн харилцах дансыг хаах магадлал өндөр байна.

Энэ нь Компанийн тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.12 заалтыг хэрэгжүүлэх нөхцөл бий болсон байна.

Өгсөн зөвлөмж:

Хувьцаа эзэмшигчдийн хурлаар төлбөрийн чадвар болон компанийн санхүүгийн үйл ажиллагаанд бий болсон хүндрэлтэй асуудлыг хэлэлцүүлж шийдвэрлүүлэх

² Дараах тохиолдолд төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол гүйцэтгэх удирдлага/ хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулна: ...61.1.4 "Компанийн өр нь хоёр жил дараалан өөрийн хөрөнгөөс илүү болж, хасах утгатай болсон..."

2. Бизнес төлөвлөгөө, гүйцэтгэлтэй холбоотой асуудал

ТУЗ-өөс баталсан нүүрсний борлуулалтын орлогын төлөвлөгөөг 361.8 мянган тонноор дутуу буюу 67.0 %-аар дутуу биелүүлж, зорилтот түвшнээс 2,860.8 сая төгрөгөөр дутуу 1,068.1 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20.1 "Захирал дараах эрх, үүрэгтэй: ...3/үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах..." заалт, Могойн гол ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс 2024 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 8 дугаар тогтоолоор баталсан бизнес төлөвлөгөө, санхүүгийн тайлангийн "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

ТУЗ компанийн бизнес төлөвлөгөөг биелэх боломжтой байдлаар баталж, гүйцэтгэлийг хангуулж ажиллах

3. Авлага, өглөгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Урьдчилж орсон орлогоор бүртгэгдсэн 8 компанийн 8,239.1 сая төгрөг, дансны өглөгөөр бүртгэгдсэн 11 компанийн 2,249.1 сая төгрөг нийт 10, 488.3 сая төгрөгийн өр төлбөр, 67.6 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна. Энэ нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" заалт, санхүүгийн тайлангийн "Эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна

Өгсөн зөвлөмж:

Цэрмүүнтрейд ХХК-тай тооцоо нийлж баталгаажуулах

4. Дотоод хяналттай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Компанийн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй байна. Энэ нь Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын хавсралт "Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ын 3.1³ дэх заалт болон "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Компанийн хөрөнгө, санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналтыг хэрэгжүүлэх

Гүйцэтгэх захиралд:

5. Орлоготой холбоотой асуудал

Илрүүлэлт:

"Тэсийн илч" ХХК-д ямар нэгэн шалгуур, үзүүлэлтгүйгээр 80.6 сая төгрөгийн нүүрсний борлуулалтын хөнгөлөлт үзүүлсэн байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 5.5 "Төрийн өөрийн өмчийг зориулалт бусаар захиран зарцуулах, нийгмийн шинжтэй төсөл, арга хэмжээнд зарцуулах, хандив, тусламж, түүнтэй адилтгах хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхийг хориглох бөгөөд энэхүү хориглолтыг зөрчсөн эрх бүхий этгээдийг албан тушаалаас чөлөөлж, учруулсан хохирлыг нөхөн төлүүлнэ" заалттай нийцэхгүй байна."

Өгсөн зөвлөмж:

³ Энэхүү журмын 1.3-т заасан "Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам"-д өөрөөр заагаагүй бол дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах үүргийг тухайн аж ахуйн нэгж, байгууллагын захиргааны асуудал хариуцсан нэгж, ажилтан (цаашид "дотоод хяналт шалгалтын нэгж, ажилтан" гэх) гүйцэтгэнэ.

Аж ахуйн нэгжүүдэд нүүрсний шалгуур үзүүлэлтгүйгээр борлуулалтын тусгай хөнгөлөлт үзүүлэхгүй байх

6. Худалдан авах ажиллагаатай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан 9 арга хэмжээг хэрэгжүүлэхдээ Худалдан авахад баримтлах төсөвт өртөгийн дээд хязгаарыг баримтлаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 "Энэ хуулийн 31.2-т зааснаас бусад тохиолдолд нийт төсөвт өртөг нь шууд худалдан авч болох төсөвт өртөгийн дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил, үйлчилгээг захиалагч шууд худалдан авч болно.", Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 02 дугаар тогтоолтой нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь заалтыг хэрэгжүүлж ажиллах

7. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

"Могойн гол" ХК-ийн 2025 оны завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар талбар дээр биет тооллогыг 54-н машин тоног төхөөрөмж, тээврийн хэрэгслийг хамруулан түүвэрлэн үзэхэд:

- 171.0 сая төгрөгийн анхны өртөгтэй элэгдлээрээ өртгөө нөхсөн цаашид ашиглах боломжгүй 20 хөрөнгийг өмч хамгаалах байнгын зөвлөлөөр хэлэлцэж шийдвэрлээгүй байна. Энэ нь: НББОУС 16-д үндсэн хөрөнгийн тодорхойлолтод нийцсэн, дараах хоёр шалгуурыг хангасан хөрөнгийг үндсэн хөрөнгөөр хүлээн зөвшөөрнө: Тухайн хөрөнгөтэй холбоотой ирээдүйн эдийн засгийн үр өгөөж нь тухайн аж ахуйн нэгжид орох магадлалтай байх... гэж заасантай нийцэхгүй байна."

Өгсөн зөвлөмж:

Зээлийн хүүгийн зардлыг аккрузал сууриар бүртгэж, тайлагнаж байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
					Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Эксковатор 5а машинд их засвар хийхэд зарцуулсан 583.2 сая төгрөгийг капиталжуулаагүй байна	1	583,227.9	1	583,227.9	1	583,227.9				
Дүн	1	583,227.9	1	583,227.9	1	583,227.9				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөг/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Зорилтот түвшнийг хангаж ажиллаагүй	1	1,674,085.4					1	1,674,085.4
Өмнөх аудитын шийдвэрийг хэрэгжүүлээгүй зөрчил	1	558,789.7			1	558,789.7		
Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр ТУЗ-ын гишүүний цалинг 3.5 сая төгрөгөөр тогтоож, Засгийн газрын баталсан дээд хязгаараас 0.3 сая төгрөгөөр буюу нийт 23.9 сая төгрөгөөр илүү тооцож олгосон байна.	1	23,904.0			1	23,904.0		
"Тэсийн илч" ХХК-д ямар нэгэн шалгуур, үзүүлэлтгүйгээр 80.6 сая төгрөгийн нүүрсний борлуултын хөнгөлөлт үзүүлсэн байна.	1	80,582.9					1	80,582.9
67.6 сая төгрөгийн авлага, 10,488.3 сая төгрөгийн өр төлбөрийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй.	1	10,555,895.5					1	10,555,895.5
Богино хугацаат өглөг 1,192.1 сая төгрөгөөр буурсан боловч нийт дүнгээр 15,831.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь компанийн хэвийн үйл ажиллагаа явуулахад хангалтгүй, шүүхийн шийдвэрээр компанийн харилцах дансыг хаах магадлал өндөр байна.	1						1	
171.0 сая төгрөгийн анхны өртөгтэй элэгдлээрээ өртгөө нөхсөн цаашид ашиглах боломжгүй 20 хөрөнгийг өмч хамгаалах байнгын зөвлөлөөр	1						1	

хэлэлцэж шийдвэрлээгүй байна								
Компанийн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй байна	1						1	
Дүн	8	12,893,257.5			2	582,693.7	6	12,310,563.8

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөг/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан 9 арга хэмжээг хэрэгжүүлэхдээ худалдан авахад баримтлах төсөвт өртөгийн дээд хязгаарыг баримтлаагүй байна.	1	484,732.8					1	484,732.8
Дүн	1	484,732.8					1	484,732.8



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

№ 114/12270436/ХВА-2026/
020/НА-СИА-04047

Мөрөн сум

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн “Могойн гол” ХК-ийн 2025 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

“Могойн гол” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2025 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн хурлын шийдвэрээр Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний цалинг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн “Аргачлал батлах тухай” 174 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан аргачлалд нийцүүлэн тооцохгүйгээр 3,500,000 (гурван сая таван зуун мянга)-н төгрөгөөр тогтоосон нь Засгийн газрын 2023 оны 84 тогтоолд заасан Төрийн өмчит компаниудын ТУЗ-ын гишүүний цалингийн зардлын дээд хязгаараас 332,000 (гурван зуун гучин хоёр мянга) төгрөгөөр нийт 23,904,000 (хорин гурван сая есөн зуун дөрвөн мянга) төгрөгөөр илүү тооцож, олгосон байна.

Энэ нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн “Аргачлал батлах тухай” 174 дүгээр тогтоолын 3 дэхь заалт “Төрийн өмчийн оролцоотой компани, орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой компанийн Төлөөлөн удирдах зөвлөл, Засаг дарга, Иргэдийн төлөөлөгчдийн хуралд аргачлалыг мөрдөж ажиллахыг зөвлөсүгэй” гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.11-т “Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний цалинг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн 174 дүгээр тогтоолоор баталсан аргачлалын дагуу тогтоож, Хувьцаа эзэмшигчдийн хурлаар батлуулж, биелэлтийг 2026 оны 6 дугаар сарын 20-ны дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар¹т ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг “Могойн гол” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга(Г.Гандэлгэр)-д даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР
С.ГАНСҮХ

¹ Монгол Улс, Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 8-р баг, Хөвсгөл аймгийн ЗДТГ-ын байр 3 давхар 303 тоот